



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 516

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.5 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн нийт 595,230,929.15 (таван зуун ерэн таван сая хоёр зуун гучин мянга есөн зуун хорин есөн төгрөг арван таван мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 218,251,331.18 (хоёр зуун арван найман сая хоёр зуун тавин нэгэн мянга гурван зуун гучин нэгэн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, С.Батболд, гүйцэтгэх захирал Д.Баттөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон хөрөнгө худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 10 дугаар сарын 20-ний
өдрийн 5/6 дүгээр тогтоолын хавсралт

**"МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр марк,	Ашиг лал тад орсон он	Тоо шир хэг	нэгжийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримт лагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Бизнес ангиллын дан суудал	2011	2	124,110,457.38	248,220,914.75	91,014,325.90	157,206,588.85	157,000,000.00
2	Бизнес ангиллын хос суудал /4 хос/	2011	8	43,376,251.80	347,010,014.40	127,237,005.28	219,773,009.12	219,000,000.00
					595,230,929.15	218,251,331.18	376,979,597.97	376,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				595,230,929.15 (таван зуун ерэн таван сая хоёр зуун гучин мянга есөн зуун хорин есөн төгрөг арван таван мөнгө)	218,251,331.18 (хоёр зуун арван найман сая хоёр зуун тавин нэгэн мянга гурван зуун гучин нэгэн төгрөг арван найман мөнгө)	376,979,597.97 (гурван зуун далан зургаан сая есөн зуун далан есөн мянга таван зуун ерэн долоон төгрөг ерэн долоон мөнгө)	376,000,000.00 (гурван зуун далан зургаан сая)